



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 223

Улаанбаатар хот


Г

Г

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- Дархан ширхэнцэг ХХК-ийн Орхон аймгийн нутаг дэвсгэрт “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх” 13400117 тоот тусгай зөвшөөрөл болон Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурvas ашиглах” 23410058 тоот тусгай зөвшөөрлийг 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 2029 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасугай.
- Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.



А.ЛУВСАН-ОЧИР
Н.МАНДАХБААТАР
А.ҮЙЛСТӨГӨЛДӨР